



Хүн амын бүртгэл тооллогын комиссар цаасан маягт тарааж байна

2021 оны 4-р сарын 17-ноос эхэлнэ цахимаар бүртгүүлж амжаагүй хүмүүст бүртгэл тооллогын комиссарууд цаасан маягт тарааж байна. Маягтын жишээг [эндээс](#).

Та цаасан маягт авсан ч **цахимаар бүртгүүлж болох** бөгөөд 2021 оны 5-р сарын 11 хүртэл боломжтой. Та зөвхөн нэг хувилбарыг ашиглана уу! Цаасан маягт нь зөвхөн чех хэл дээр тул, орчуулсан маягтыг хүсэж болно.

Англи хэл дээрх маягтыг [эндээс](#).

Герман хэл дээрх маягтыг [эндээс](#).

Польш хэл дээрх маягтыг [эндээс](#).

Роман хэл дээрх маягтыг [эндээс](#).

Орос хэл дээрх маягтыг [эндээс](#).

Украин хэл дээрх маягтыг [эндээс](#).

Вьетнам хэл дээрх маягтыг [эндээс](#).

Бүртгэлийн комиссарууд харагдахаар газар комиссар гэдэг үнэмлэхээ зүүсэн байх бөгөөд таныг хүсвэл өөрийн биеийн байцаалтаа үзүүлэх үүрэгтэй.

Зочлох өдрийн цагийг тухай танд түрүүлж мэдэгдэх бөгөөд жишээ нь: байрны хаалгана дээр, мэдэгдлийн самбарт эсвэл шуудангийн хайрцагт мэдэгдэх хуудас хийсэн байна. Зочлох өдрийн цагийг өөрчлөх боломжгүй. Хэрвээ та гэртээ байхгүй тохиолдолд өөр өдөр цагт комиссар ирэх бөгөөд гурав дахь удаа зочлохгүй. Цаасан маягтыг та дараах холбогдох газраас авах боломжтой (Усти аймгийн холбогдох газрын жагсаалтыг [эндээс](#)).

Маягтыг бөглөх үндсэн тусламж нь маягтын асуулт болгонтой хамт байх болно.

Хэрхэн зөв маягтыг бөглөх вэ?

- Бөглөх дөө хар эсвэл цэнхэр өнгийн үзгээр бичих.
- Маягтын жишээ шиг том үсгээр дармалдаж бичих.
- Цагаан дөрвөлжин хэсэгт бичнэ үү.
- Тэр хэсэгт зөвхөн нэг үсэг, таслал эсвэл зураас зурна.
- Урт хариулт гарч ирвэл, товчилж бичнэ үү.
- Олон сонголттой хэсэг дээр зөв хариултад хэрээс зурж бичнэ үү.
- Зөвхөн нэг хариулыг сонгон уу, өөрөөр бичээгүй бол.
- Буруу зурж тэмдэглэвэл, зураад хажууд нь бичнэ үү.

Бөглөсөн маягтыг холбогдох газард хураалгах эсвэл ирсэн дугтуйнд бөглөсөн маягтайгаа хамт явуулна. Дугтуйнд илгээх хаяг бичсэн байх бөгөөд илгээлт нь үнэ төлбөргүй.